

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	07	Өдөр	07
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Хүнд өвчний даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2021-01-18		ЗТ-21/01-020	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Хувь хүн болон байгууллагын ажиллагсдын эрүүл мэнд;					
	Даатгалын үндсэн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Голлох хорт хавдар - Тодорхой хэмжээнд илэрсэн зүрхний шигдээс - Тархины цус харвалт - Титэм судасны мэс засал - Бөөрний дутагдал - Зүрхний хавхлага солих нээлттэй мэс засал - Түлэгдэлт - Эрхтэн, ясны чөмөг шилжүүлэн суулгах - Тархмал хатуурал - Гол судасны мэс засал - Сохрох (Хараагаа алдах) - Саажилт (Мөчдийн үйл ажиллагаа алдагдах) 					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Насны ангилал		Хураамжийн хувь			
		18-25		0.232%			
26-30		0.454%					
31-35		0.699%					

	36-40	1.043%
	41-45	1.593%
	46-50	2.364%
	51-55	3.362%
	56-60	5.535%

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМААРАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгагч нь Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д зааснаас гадна дараах үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний хэсгийг олгохоос татгалзах эрхтэй. Үүнд:
 - 1.1. Асуулгын хуудсыг үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөн даатгагчид хүлээлгэн өгөөгүй мөн шаардлагатай тохиолдолд гэрээнд заасан шинжилгээний хариуг хавсаргаагүй бол;
 - 1.2. Даатгуулагч нь даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бүрдүүлэхээр завдсан, даатгал хийлгэх үедээ даатгалын зүйлтэй холбоотой мэдээлэл худал буюу зөрүүтэй өгсөн бол;
 - 1.3. Гэрээнд зааснаас өөр бусад хүнд өвчнөөр өвчилсөн;
 - 1.4. Даатгуулагчийн даатгалын гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө оношлогдсон өвчин эмгэгт;
 - 1.5. Төрөлхийн гажиг болон үүнээс үүдсэн бие мах бодийн согог;
 - 1.6. Амиа хорлолт, амиа хорлох оролдлого, санаатайгаар өөрийгөө гэмтээх болон онц аюулт үзэгдэлд санаатайгаар өртөх (бусдын амь насыг аврах оролдлогоос бусад) болон галзуурал болон гэмт хэргийн үйлдлээс үүдсэн хүнд өвчлөл;
 - 1.7. Стресс, сэтгэцийн хямрал, нойрны эмгэг, архи, согтууруулах ундаа, мансууруулах бодистой холбоотой эмчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ болон сэтгэц болон мэдрэлийн эмгэгүүд;
 - 1.8. Жирэмслэлт, зулбалт (ослын улмаас зулбаснаас бусад), үр хөндөлт, төрөлт, зохиомлоор үргүй болгох, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, үргүйдэлтэй холбоотой эмчилгээ;
 - 1.9. Дархлалын олдмол хомстол синдром буюу ДОХ болон ДОХ-той холбоотой цогц ХДХВ болон эдгээрээс шалтгаалсан ямарваа өвчлөл, өвчин бактерийн халдвар болон хүнд өвчлөл;
 - 1.10. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, эмчийн зааваргүйгээр дур мэдэн хэрэглэсэн эм бэлдмэлийн улмаас үүссэн хүнд өвчлөлийн нөлөө;
 - 1.11. Террорист болон террорист байгууллагын гишүүн, мансууруулах бодисын наймаачин, цөмийн, химийн болон биологийн зэвсгийг зөөвөрлөсөн этгээдэд шууд болон шууд бус байдлаар үүссэн аливаа хохирол, гэмтэл болон хүнд өвчлөл;
 - 1.12. Дайн, хувьсгал, түрэмгийлэл, аливаа дайн байлдаан болон террорист үйл ажиллагааны үр нөлөө;
 - 1.13. Эмчийн зөвлөгөөг дагаж мөрдөөгүйгээс үүдсэн хүнд өвчлөл;
 - 1.14. Мэргэжлийн ур чадвар шаарддаг, аюултай спорт, спорт тоглоомоос үүдсэн хүнд өвчлөл, бэртэл гэмтэл;
 - 1.15. Бүх төрлийн цэргийн сургалт, сургуулилт, байлдааны ажиллагаанд оролцох, тэсэрч дэлбэрэх бодис, химийн зэвсгийн нөлөөнд автсан, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд оролцсоноос үүдсэн хүнд өвчлөл;
 - 1.16. Урьдчилсан сэргийлэх үзлэг, асаргаа сувилгаа хийлгэх;

- 1.17. Даатгуулагч даатгалын асуулгын хуудсанд тусгагдаагүй аливаа өндөр эрсдэлтэй ажил мэргэжил, үйл ажиллагаа эрхэлснээс үүдэн хүндээр өвчилсөн;
- 1.18. Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй бол;
- 1.19. Нөхөн төлбөрийн өргөдлийн маягтыг бөглөх эмчийн зардал болон аливаа бичиг баримтын зардал;
- 1.20. Даатгуулагч нь даатгагчид мэдэгдэлгүйгээр оршин суух газраа өөрчилсөн, оршин суух газраа өөрчилсөн талаар тогтоосон хугацаанд мэдэгдээгүй;
- 1.21. Байгал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэлд өртсөний улмаас үүссэн хүнд өвчлөл;
- 1.22. Цөмийн зэвсэг, цацраг идэвхит бодисын нөлөөллөөс үүдсэн хүнд өвчлөл;
- 1.23. Даатгуулагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй;
- 1.24. Хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.